

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Авто тээврийн хэрэгслийн даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Авто тээврийн хэрэгслийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэн батлах тухай		2021-01-11		ЗТ-21/01-016	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл					
	Даатгалын үндсэн эрсдэл	Байгаль, хөдөлгөөний, хөдөлгөөний бус, зогсоол, сантехник, гал					
	Даатгалын нэмэлт эрсдэл	Хулгай, жолоочийн гэнэтийн осол					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	1%-3%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгуулагч нь даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, бүрдүүлэхээр завдсан, даатгал хийлгэх үедээ даатгалын зүйлтэй холбоотой мэдээлэл худал буюу зөрүүтэй өгсөн бол;
2. Даатгалын тохиолдол болсныг нотлох боломжгүй бол;
3. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгуулагч өөрөө гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан бөгөөд түүний улмаас учирсан хохирол болон хууль бусаар ашиглаж явснаас үүдсэн аливаа хохирол;
4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлд гарсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн алдагдал;
5. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээ болон даатгалын нөхцөлүүдэд тусгагдсан баримт материалыг даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 90 хоног дотор даатгагчид хүлээлгэн өгөөгүй бол;
6. Даатгуулагч даатгагчтай тохиролцолгүйгээр даатгалын зүйлийг нөхөн сэргээсэн нь хохирлын бодит үнэлгээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдолд;
7. Гэрээнд өөрөөр заагаагүй бол МУ-ын нутаг дэвсгэрээс гадна учирсан аливаа хохирол;
8. Даатгуулагч, түүний ажилтны сэтгэцийн эмгэг болон эрх зүйн чадамжгүй үед хийсэн аливаа үйлдэл, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн болон ядарсан үед хийсэн үйлдлийн улмаас үүдсэн хохирол;
9. Байлдааны зэвсэг хэрэглэх, атомын болон цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт цэнэгийн нөлөөгөөр үүссэн хохирол;
10. Дайн, дайны шинжтэй тэмцэл, хувьсгал, маргаан, булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, мина хаях, бөмбөг дэлбэлэх зэрэг үйл ажиллагаанаас үүдсэн хохирол;
11. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол нийгмийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, гэмт халдлага, террорист болон улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол;
12. Даатгуулагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол;
13. Даатгалын зүйлийн өмчлөлд өөрчлөлт орсон талаар даатгагчид хуанлын 14 хоног дотор мэдэгдэж, даатгагчаас зохих өөрчлөлтийг хийлгээгүй үед учирсан хохирол;
14. Даатгалын хураамжийн төлбөр төлөх хугацаа зөрчигдсэн бол төлөгдөөгүй хэсгийн нийт хураамжид эзлэх хувьд хувь тэнцүүлсэн хэмжээнд нөхөн төлбөр олгохгүй;
15. Тээврийн хэрэгслийг болон түүний эд ангийг зориулалтын бусаар ашигласан, ашиглалтын горимыг өөрчилсөн, даац хэтрүүлсэн, хурд хэтрүүлсэн, урсгал сөрсөн, замын үргэлжилсэн тусгаарлах шугам давсан, улаан гэрлээр уулзвар нэвтэрснээс үүдсэн хохирол;
16. Уралдаан тэмцээн, ан ав хөөж явснаас;
17. Суудлын даруулга бүс, зориулалтын малгай, хамгаалалтын хувцас хэрэглээгүйгээс учирсан хохирол;
18. Зориулалтын бус аргаар тээврийн хэрэгслийг халаах, асаах, тээвэрлэх, тээвэрлүүлэх, чирэх, чирэгдэх оролдлого хийх болон түрэх, түлхэх оролдлого хийснээс үүдсэн хохирол;
19. Даатгуулагч, түүний жолоо барих эрх олгосон этгээд жолоочийн албан журмын даатгалд хамрагдаагүй, жолоодох эрхийн үнэмлэхгүй, жолоодох эрх нь хасагдсан үед учирсан хохирол болон зам тээврийн ослын хэрэг нь шүүх, прокурор болон цагдаагийн байгууллагаар шалгагдаж байгаа этгээд жолоодсоноос үүдсэн хохирол;

20. Тоормосны систем, дугуй, шил арчигч, цан үлээгүүр, жолооны механизм нь ашиглахыг хориглосон эвдрэл, гэмтэлтэй, техникийн зөрчилтэйгөөр хөдөлгөөнд оролцсоноос үүдсэнийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан бол;
21. Зам тээврийн осолд холбогдсон жолооч тээврийн хэрэгслээ нэн даруй зогсоож, ослын дохионы гэрлээ асаах ба ослын зогсолтын тэмдгийг шаардлагын дагуу тавиагүйгээс үүдсэн хохирол, тээврийн хэрэгсэл болон осолд холбогдол бүхий эд юмсыг байрнаас нь хөдөлгөсөн бол (МУ-ын ЗХД-ын 3.5а);
22. Осолд холбогдсон тээврийн хэрэгсэл нь бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаасны улмаас зорчих хэсгийг чөлөөлөх мөн осолд нэрвэгдсэн хүнийг эмнэлгийн байгууллагад уг тээврийн хэрэгслээр хүргэх зайлшгүй тохиолдолд хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулан осолд холбогдол бүхий эд мөрийн баримт, тухайн тээврийн хэрэгслийн ул мөрийн байрлалыг тодорхой тэмдэглээгүйгээр байрнаас нь хөдөлгөсөн бол (МУ-ын ЗХД-ын 3.5в);
23. Даатгуулагч эсхүл зөвшөөрөгдсөн этгээд нь тээврийн хэрэгслээ үл хөдлөх буюу өөрөөс нь бусад этгээд хөдөлгөх боломжгүй болгох арга хэмжээ аваагүйгээр орхин явснаас үүдсэн хохирол;
24. Даатгуулагч нь даатгагч болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийн өмнө өөрийн бурууг хүлээн үүрэг хариуцлага хүлээхээр тохиролцсон бол;
25. Нийтийн эзэмшлийн ил зогсоол болон гаражид тээврийн хэрэгслээ байрлуулсны дараа түлхүүрээ бусдад үлдээн явснаас үүдэн гарсан хохирол;
26. Ердийн элэгдэл хорогдол, механик эвдрэл болон дугуй, түлхүүрэнд учирсан хохирол;
27. Даатгалын зүйл дотор байсан эд зүйлс, тээвэрлэж явсан зорчигч, ачаанд болон тэдгээрээс үүдэн гарсан хохирол, бусдад буюу гуравдагч этгээдэд учруулсан хохирол;
28. Үйлдвэрлэлийн дефектээс болоод буруу суурилуулсан, угсарсан, задалснаас үүдэн гарсан, тэдгээрийг засварласан аливаа зардал;
29. Бусад буюу гуравдагч этгээдэд учруулсан хохирол;
30. Даатгалын үнэлгээнээс хэтэрсэн хохирол, ослын дараах улсын дугаар сэргээх болон тэнхлэг тохиргооны зардал;
31. Зөвшөөрөгдсөн нэмэлт тоноглол, эд ангийг нэмэлтээр даатгаагүй үед нэмэлт тоноглолд учирсан хохирол;
32. Даатгалын гэрээ байгуулагдсанаас хойш 24 цагийн дотор учирсан аливаа хохирол (Хэрэв даатгуулагы хугацааны завсаргүйгээр даатгалын гэрээгээ сунгасан эсхүл даатгуулагч даатгагчийн салбар нэгж дээр өөрийн биеэр ирж даатгуулсан тохиолдолд уг заалт хамаарахгүй);
33. Даатгуулагч нэг удаагийн төлөлтөөр даатгалын хураамжийг төлөх нөхцөлтэйгөөр гэрээг байгуулсан боловч хураамжаа төлөөгүй байх үед эсхүл даатгалын хураамжийг хэсэгчилж төлөх нөхцөлтэйгөөр гэрээг байгуулсан боловч гэрээнд заагдсан хуваарийн дагуу эхний төлбөрөө төлөөгүй байх үед үүссэн хохирол;
34. Энэхүү гэрээний Хавсралт №2-д заасан “Автотээврийн хэрэгслийн даатгалын багц” хүснэгтээс сонгосон даатгалын хамгаалалтын багцад заагаагүй эрсдэлийн улмаас учирсан хохирол;
35. Хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан бусад тохиолдол.